



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/277

Алтай хот

Согтууруулах ундааны хариуцлагатай  
үйлчилгээний сургалтын жишиг хөтөлбөр,  
модуль, гэрчилгээний загвар батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны "Журам болон жишиг төлбөрийн хэмжээг батлах тухай" А/04 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд зохион байгуулах "Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалт"-ын жишиг хөтөлбөрийг нэгдүгээр, сургалтын модулийг хоёрдугаар, гэрчилгээний загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шалгарсан Төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай

3. Сургалтыг журмын хүрээнд чанартай зохион байгуулж, хэрэгжилтийг улирал тутам тайлагнаж ажиллахыг "Болормаа сан" НҮТББ-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2023 оны 05  
дугаар сарын 05-ны өдрийн АЗТД дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

## СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨР

Нэг.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг таниулах

1.1.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн танилцууллага, ерөнхий ойлголт

1.2.Архидан согтуурахтай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн талаар Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомжинд хэрхэн тусгасан, оногдуулах шийтгэл;

1.3."Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын журам"-ын ойлголт, үйлчилгээний байгууллагуудын мөрдөх шаардлага;

1.4.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, түүний төрөл, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох;

1.5.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхэд хориглох зүйл, цагийн хязгаарлалт, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавигдах шаардлага, эзэмшигчийн хариуцлага;

Хоёр.Үйлчлүүлэгчийг согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхээс урьдчилан сэргийлэх

2.1.Үйлчлүүлэгчийг согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхээс урьдчилан сэргийлэх талаар;

Гурав.Согтууруулах ундааны нийгэмд үзүүлэх нөлөөлөл

3.1.Согтууруулах ундааны хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, хүний бие согтууруулах ундааг хэрхэн боловсруулах талаар;

3.2.Согтууруулах ундааны нийгэмд үзүүлэх нөлөөлөл, сөрөг үр дагавар;

3.3.Архи, согтууруулах ундаа хүний оюун ухаан, сэтгэл зүй, зан араншинд хэрхэн нөлөөлөл;

Дөрөв.Согтууруулах ундааны хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

4.1.Архинд донтох эмгэг, архины хордлого ба эрсдэл;

4.2.Хорт хавдар, элэгний хатуурал зэрэг өвчин нь архитай хэрхэн хамаарал;

Тав.Насанд хүрээгүй, эсвэл согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үйлчлүүлэгчид согтууруулах ундаагаар үйлчлэхээс зайлсхийх арга барил;

5.1.Согтууруулах ундаагаар насанд хүрээгүй болон хэтрүүлэн хэрэглэсэн үйлчлүүлэгчид үйлчлэхээс зайлсхийх арга барил;


Аймгийн Засаг даргын 20<sup>03</sup> оны <sup>05</sup>  
 дугаар сарын <sup>05</sup>-ны өдрийн <sup>А/03</sup> дугаар  
 захирамжийн хоёрдугаар хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ  
 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТЫН МОДУЛЬ

Д/д	Сэдэв	Агуулга	Цаг
1.	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидаан согтуурахтай тэмцэх тухай хуулийн танилцууллага, ерөнхий ойлголт	-Хуулийн ерөнхий ойлголт, зорилго -Хуулийн үйлчлэх хүрээ -Нэр томъёоны тайлбар -Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх журам -Үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээнд тавих хяналт -Согтууруулах ундааны хэрэглээг нэмэгдүүлэх зорилго бүхий үйл ажиллагааг хориглох	Сургалтын үргэлжлэх цаг 20 минут
2.	Үйлчлүүлэгчийг согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхээс урьдчилан сэргийлэх нь	Архи гэж юу вэ, бие махбодыг хянах, удирдах чадварт нөлөөлөх нь -Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар иргэний эрх, үүрэг -Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хуулийн этгээдийн нийтлэг үүрэг -Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, байгууллагыг урамшуулах нь -Гэмт хэргийн талаарх мэдээллийг иргэдээс төлбөртэй авах -Үйлчлүүлэгчийг согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхээс урьдчилан сэргийлэхийн тулд бид юу хийх вэ. -Согтууруулах ундааг зохистой хэрэглэх, зөв соёлыг түгээе	Сургалтын үргэлжлэх цаг 20 минут
3.	Согтууруулах ундааны нийгэмд үзүүлэх нөлөөлөл, сөрөг үр дагавар	-Согтууруулах ундааны нийгмийн асуудал -Архины хэрэглээнээс үүдэн хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгэм- эдийн засагт гарах сөрөг нөлөө -Төрөөс баримтлаж байгаа бодлого, хөтөлбөрт хэрхэн тусгагдсан бэ?	Сургалтын үргэлжлэх цаг: 20 минут
4.	Архи, согтууруулах ундаа хүний оюун ухаан, сэтгэл зүй, зан араншинд хэрхэн нөлөөлөх вэ.	-Согтууруулах ундааны талаарх статистик судалгаа -Архитай холбоотой түрэмгийлэл ба хүчирхийлэл -Архины сөрөг нөлөөлөл -Гэр бүлийн талаар архины нөлөөлөл	Сургалтын үргэлжлэх цаг 20 минут
5.	Согтууруулах ундааны хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, хүний бие согтууруулах ундааг хэрхэн боловсруулдаг	-Архи согтууруулах ундааны мөн чанар, хор хөнөөлийн дэлхийн болон Монгол улсад байгаа бодит байдал -Стандарт хэмжээ -Архи согтууруулах ундааны хүний бие махбодод задарч, хоргүйжэх процесс -Архи хүний тархи, хоол боловсруулах эрхтэн, зүрх судас, амьсгалын эрхтэн, нөхөн үржихүйн	Сургалтын үргэлжлэх цаг 25 минут

	вэ?	эрхтэн тогтолцоо, арьс булчинд хэрхэн нөлөөлдөг вэ. -Архинаас үүдэлтэй эрүүл мэндийн болон хөдөлмөрийн чадвар, түүнд хэрхэн нөлөөлөх вэ. -Нийгмийн харилцаанд хэрхэн нөлөөлөх вэ?	
6.	Архинд донтох эмгэг, хордлого эрсдэл архины ба	-Архинд донтох эмгэг гэж юу вэ? -Архиний богино хугацаанд үзүүлэх нөлөөлөл -Донтолтын ангилал (цочмог, дунд, хүнд согтолт) -Архины архаг хордлого буюу архинд донтох эмгэгийн үе шат -Архи, архины хамаарлын түвшин, түвшинг үнэлэх -Шартах хам шинж гэж юу вэ?	Сургалтын үргэлжлэх цаг 25 минут
7.	Хорт хавдар, элэгний хатуурал зэрэг өвчин нь архитай хэрхэн хамааралтай вэ	-Архи согтууруулах ундааны хэрэглээтэй холбоотой хоол боловсруулах эрхтэнд үүсдэг эмгэгүүдийн тухай -Элэгний архаг үрэвсэл хатуурал үүсгэдэг тухай -Хорт хавдар ба архины хамаарал -Архинаас үүдэлтэй нас баралт	Сургалтын үргэлжлэх цаг 20 минут
8.	Насанд хүрээгүй, эсвэл согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үйлчлүүлэгчид согтууруулах ундаагаар үйлчлэхээс зайлсхийх арга барил	-Үйлчлүүлэгч 21 нас хүрээгүй гэх үндэслэл байгаа тохиолдолд үйлчлэхийн өмнө бичиг баримтыг заавал шалгах. -СУЭХТАСТТ хуулийн 21-р зүйлд заасныг баримтлах -Үйлчилгээ үзүүлэхээс татгалзах арга барил	Сургалтын үргэлжлэх цаг 15 минут
9.	Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын журмын ойлголт, үйлчилгээний байгууллагуудын мөрдөх шаардлага	-Журмаар зохицуулах харилцаа -Хариуцлагатай үйлчилгээг эрхэмлэх, эзэмших -Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийн өмнө шаардлагатай бол баримт бичгийг шалгах -Үйлчлүүлэгч хэтрүүлэн хэрэглсэн үед үйлчилгээг зогсоох, хэрхэн харилцах	Сургалтын үргэлжлэх цаг 15 минут
10.	Архидан согтуурахтай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн талаар Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомжинд хэрхэн тусгасан, оногдуулах шийтгэл	-Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил, хариуцлага, шийтгэл -Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах, түгээх -Гэр бүлийн хүчирхийлэл, танхайрах зөрчилд согтууруулах ундааны нөлөөлөл, зөрчил, шийтгэл	Сургалтын үргэлжлэх цаг 20 минут
11.	Согтууруулах	-Согтууруулах ундаа худалдах, түүгээр	Сургалтын

	ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, түүний төрөл, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл.	үйлчлэх ТЗ-н төрөл -Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай түдгэлзүүлэх, сэргээх зүйл: -согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх ТЗ-г хүчингүй болгох үндэслэл	үргэлжлэх цаг 20 минут
12.	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхэд хориглох зүйл, цагийн хязгаарлалт, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавигдах шаардлага, эзэмшигчийн хариуцлага	-Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох газар, цагийн хязгаарлалт -Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхэд хориглох зүйл -Согтууруулах ундаагаар үйлчлэх ТЗ эзэмшигчдэд тавигдах тусгай шаардлага -Согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох -Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан -Татвар, хураамж төлөх, онцгой албан татвар	Сургалтын үргэлжлэх цаг 20 минут



Аймгийн Засаг даргын 20<sup>23</sup> оны <sup>05</sup>  
дугаар сарын <sup>05</sup>-ны өдрийн <sup>№79</sup> дугаар  
захирамжийн гуравдугаар хавсралт

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 2023/...

.....сумын .....ХХК-ийн ..... (рестарон,  
баар, караоке, зоогийн газар)-ын .....овогтой .....-нд  
"Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалт"-д 2023 оны ...  
дугаар сарын ...-ны өдөр хамрагдаж, тэнцсэн тул гэрчилгээ олгов.

Хүчинтэй хуацаа: 3 жил

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

2023...оны ...дүгээр сарын ...-ны өдөр

Бүртгэлийн дугаар...